



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 04 дүгээр сарын 08  
№13 /1211/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

237. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 88 1050

238. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 107 1050

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

239. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 173 1051

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

240. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцсэн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай Дугаар 01 1065

• ᠘᠐᠐᠐	• 7᠐᠐᠐	• ᠔᠐᠐᠐	• 0᠒᠐᠐		
᠒᠐᠒᠐᠐6	᠐᠒᠒᠐᠐6	6᠒᠒᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6
᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6	᠒᠒᠑᠐᠐6



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 11 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бельгийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Одын Очийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бельгийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанвандангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, мөн зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Лхүндэвийн Атарцэцэг, Хээмчигийн Сонинбаяр нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 6 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар  
хот

### **Дүрэм шинэчлэн батлах тухай**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад үүрэг болгосугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 200 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**А.АРИУНЗАЯА**

Засгийн газрын 2021 оны 173 дугаар  
тогтоолын хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД,  
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИССЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1-д заасан чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Төв болон Салбар комиссын эрх үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг тогтоон мөрдүүлэхэд оршино.

1.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс (цаашид “Төв комисс” гэх) нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комисс (цаашид “Салбар комисс” гэх) нь аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлого, хөгжлийн асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын дэргэд тус тус ажиллана.

1.3.Хүн амын нягтрал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц зэргийг харгалзан сум, тосгонд Салбар комисс байгуулан ажиллуулж болно.

1.4.Салбар комисс нь орон тооны бус байна.

1.5.Төв болон Салбар комисс нь үйл ажиллагаандаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ дүрмийг мөрдөнө.

1.6.Төв болон Салбар комисс нь энэ дүрмийн 1.5-д заасан хууль тогтоомжид зааснаас гадна дараах зарчмыг мөрдөж ажиллана:

1.6.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ашиг сонирхол, өвөрмөц хэрэгцээ, эрхэм чанарыг хүндэтгэх;

1.6.2.хүүхдийн хувийн нууцыг хадгалах, хамгаалах;

1.6.3.багаар ажиллах, хамтын шийдвэр гаргах;

1.6.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

1.6.5.үйлчилгээг чанартай, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх;

1.6.6.үнэн зөв мэдээллээр хангах.

1.7.Төв болон Салбар комисс нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.8.Төв болон Салбар комисс нь эрх, үүргийнхээ хүрээнд 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь дүгнэлт, шаардлага, зөвлөмжийн хэлбэртэй байна.

1.9.Төв комиссын үйл ажиллагааны зардал, гишүүдийн цалин болон Салбар комиссын гишүүдэд олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлнэ.

1.10.Аймаг, дүүргийн Засаг дарга нь Салбар комиссын үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, албан байраар болон гишүүдийн ажиллах нөхцөлийг хангах үүрэгтэй бөгөөд Салбар комиссын тайланг жил бүр хэлэлцэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллана.

Хоёр.Төв болон Салбар комиссын бүрэлдэхүүн

2.1.Төв комиссыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлагдсан орон тооны хязгаарт багтаан байгуулна. Төв комисс нь дарга, нарийн бичгийн дарга, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэй байна.

2.2.Төв комиссын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хүүхдийн эмч, эсхүл ерөнхий мэргэжлийн эмч, боловсролын болон

нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн нь нийгмийн хамгаалал, боловсрол, сэтгэл судлал, эрх зүй чиглэлийн мэргэжилтэй байна.

2.3.Төв комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг Төрийн албаны тухай хууль болон энэ дүрмийн 2.2-т заасан шаардлагыг харгалзан хуулийн дагуу сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.

2.4.Төв комисс нь дэргэдээ эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байж болно.

2.5.Салбар комиссын бүрэлдэхүүнийг тухайн аймаг, дүүргийн Засаг дарга батлах бөгөөд дарга, гишүүдээс бүрдсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.6.Салбар комиссын нарийн бичгийн даргын үүргийг тухайн аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн холбогдох ажилтан, эсхүл аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

2.7.Салбар комиссын дарга нь тухайн аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлого, хөгжлийн асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын дарга, гишүүд нь тухайн аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (Эрүүл мэндийн төв)-ийн хүүхдийн эмч, мэдрэлийн эмч, боловсролын асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын тусгай хэрэгцээт (тэгш хамран сургах) боловсролын асуудал хариуцсан ажилтан, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын зорилтот бүлгийн хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

2.8.Салбар комиссын гишүүнээр ажиллах энэ дүрмийн 2.7-д заасан төрийн бус байгууллагын төлөөлөл нь ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

### Гурав.Төв комиссын эрх, үүрэг

#### 3.1.Төв комисс нь дараах эрхтэй байна:

3.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах асуудлаар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын болон холбогдох бусад байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

3.1.2.хууль тогтоомжийн хүрээнд гаргасан Салбар комиссын шийдвэрийг хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагаас шаардах, биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

3.1.3.Салбар комиссын хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

3.1.4.шаардлагатай гэж үзвэл Салбар комиссын шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг магадлах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг Салбар комиссын хуралд оролцуулах, дүгнэлт гаргуулах;

3.1.5.Салбар комиссын гишүүн нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх, түүнийг өөрчлөх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

3.1.6.үйл ажиллагаандаа шаардагдах зардлыг батлуулж, зориулалтын дагуу зарцуулах;

3.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

#### 3.2.Төв комисс нь дараах үүрэгтэй байна:

3.2.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар дундын үйл ажиллагааг ялдуулан зохицуулах;

3.2.2.Салбар комиссын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөмж, чиглэл өгөх болон Салбар комиссын гишүүдийг сургалтад хамруулах, чадавхжуулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;



3.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх, хамтран ажиллах;

3.2.4.хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үнэлэх, тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, олон нийтэд чиглэсэн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг бүх хэлбэрээр зохион байгуулах;

3.2.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх хууль, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;

3.2.6.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, холбогдох үйл ажиллагаандаа татан оролцуулах;

3.2.7.Төв болон Салбар комиссын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариу өгөх;

3.2.8.Салбар комиссын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа, хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.2.9.Төв болон Салбар комиссын үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн дүгнэж, жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх;

3.2.10.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

3.3.Төв комисс нь Төв болон Салбар комиссын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэхдээ энэ дүрмийн 2.4-т заасан орон тооны бус зөвлөлтэй хамтарсан хурал зохион байгуулж болно.

3.4.Төв комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл асуудлаа шүүхэд хандаж шийдвэрлүүлж болно.

## Дөрөв.Салбар комиссын эрх, үүрэг

### 4.1.Салбар комисс нь дараах эрхтэй байна:

4.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах асуудлаар тухайн орон нутаг дахь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын болон холбогдох бусад байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

4.1.2.Салбар комиссоос хууль тогтоомжийн хүрээнд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон холбогдох байгууллагаас шаардах, биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

4.1.3.шаардлагатай гэж үзвэл төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг Салбар комиссын хуралд татан оролцуулах, дүгнэлт гаргуулах;

4.1.4.эрүүл мэндийн байгууллагатай зөвшилцөн түүний байр, шаардлагатай тохиолдолд багаж хэрэгсэл, лаборатори, эм урвалжийг оношилгоо, магадалгаа хийх зорилгоор үнэ төлбөргүй ашиглах;

4.1.5.хуурамч баримт бичиг бүрдүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг цуцалж, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

4.1.6.Салбар комиссын гишүүн нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх, түүнийг өөрчлөх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

4.1.7.Салбар комиссын гишүүнийг урамшуулах, шагналд тодорхойлох санал гаргах;

4.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх.

### 4.2.Салбар комисс нь дараах үүрэгтэй байна:

4.2.1. тухайн орон нутгийн харьяалалтай, оршин суугаа хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг сунгах, цуцлах шийдвэр гаргах;

4.2.2. тухайн орон нутгийн харьяалалтай, оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах талаар шийдвэр гаргах, шаардлагатай гэж үзвэл харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.3. энэ дүрмийн 4.2.1-д заасан шийдвэрийг гаргахдаа аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (Эрүүл мэндийн төв)-ийн төрөлжсөн мэргэжлийн багийн дүгнэлтийг үндэслэх;

4.2.4. энэ дүрмийн 4.2.3-т заасан төрөлжсөн мэргэжлийн баг болон тухайн орон нутгийн Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлтэй хамтран жилд нэгээс доошгүй удаа харьяалах сум, багт ажиллаж, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлж, боловсролд хамруулах арга хэлбэрийн талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөн туслах, холбогдох боловсролын байгууллагад уламжлах арга хэмжээ авах;

4.2.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нарийвчилсан үнэлгээнд хамруулах, өвчний онош нь үнэн зөв тавигдсан эсэхийг магадлах шаардлагатай бол мэргэжлийн байгууллага, төрөлжсөн мэргэжлийн эмчид холбон зуучлах;

4.2.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тус бүрд хүүхдийн үндсэн мэдээллээс гадна эрүүл мэнд, хөгжлийн ахиц дэвшлийн талаар холбогдох мэдээллийг багтаасан хувийн хэрэг нээж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулахаар гаргасан дүгнэлтийн талаар тэмдэглэл хийж, хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.7. тухайн орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх мэдээллийн цахим санг тогтмол хөтөлж, хүүхдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг сар бүр холбогдох байгууллагаас авч тулган нягтлах, тогтмол шинэчлэх, судалгаа хийж, дүгнэлт гаргах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах;

4.2.8.Салбар комиссын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг 12 дугаар сарын 10-ны дотор, үйл ажиллагааны тайлан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх улирлын мэдээг дараа сарын 1-ний дотор, жилийн тайлан, мэдээг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Төв комисст тус тус хүргүүлж, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

4.2.9.энэ дүрмийн 4.2.8-д заасан тайлан, мэдээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байдлыг аймаг, дүүрэг, сум, хороо, тосгоноор ангилан өвчний оношоор бүлэглэж, тухайн орон нутгийн нийт хүн амд харьцуулан дүгнэлт гаргах;

4.2.10.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран хүүхдийг сэргээн засах урт хугацааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, хүүхдээ хөгжүүлэх, эмчилгээнд хамруулах, ахиц дэвшил гаргах талаар санал, зөвлөмжийг тусгай хуудсаар хүргүүлэх;

4.2.11.үйл ажиллагаандаа кэйс менежментийн аргыг ашиглаж хэлэлцүүлэг зохион байгуулах, кэйсийн сан бий болгох;

4.2.12.Төв комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай биелүүлэх;

4.2.13.Салбар комиссын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариу өгөх;

4.2.14.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд учирч буй эрсдэлт хүчин зүйл, үл хайхрах, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл болон хүүхдийн эрхийн бусад зөрчил байгаа эсэхийг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлэх;

4.2.15.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллах.

Тав.Төв болон Салбар комиссын үйл ажиллагаа

5.1.Төв болон Салбар комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь нийтийн эрх ашиг, шударга ёсыг дээдэлж, авлига, ашиг сонирхлын



зөрчлөөс ангид байж, харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэл бүхий шийдвэр гаргана.

5.2.Төв болон Салбар комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлаас олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар баталгаажна.

5.3.Төв болон Салбар комиссын хурлаар асуудал хэлэлцэхдээ тус комиссын нарийн бичгийн даргын гаргасан хэлэлцэх асуудлын дарааллыг баримтална.

5.4.Төв болон Салбар комиссын нийт гишүүдийн ирц гуравны хоёрт хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулна.

5.5.Салбар комиссын хурал энэ дүрмийн 5.4-т заасны дагуу хойшилсон тохиолдолд энэ тухай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид урьдчилан мэдэгдэж, хойшлуулсан хурлыг нөхөж зохион байгуулна.

5.6.Салбар комиссын хурлыг сард 2-оос доошгүй удаа дараах хэлбэрээр зохион байгуулна:

5.6.1.хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг байлцуулан хуралдах;

5.6.2.хүүхэд биечлэн ирэх боломжгүй тохиолдолд хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг байлцуулахгүйгээр зохих бичиг баримтад үндэслэн хуралдах;

5.6.3.цахим хэлбэрээр хуралдах;

5.6.4.нүүдлийн хэлбэрээр хуралдах.

5.7.Салбар комисс энэ дүрмийн 5.6.1-д заасан хэлбэрээр хуралдах тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмч нар хүүхдэд бодит үзлэг хийж, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүн болон холбогдох эрүүл мэндийн байгууллагын саналд үндэслэн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах асуудлыг хэлэлцэнэ.

5.8.Салбар комисс энэ дүрмийн 5.6.2-т заасан хэлбэрээр хуралдах тохиолдолд Салбар комиссын нарийн бичгийн дарга хүүхдийн амьдралын нөхцөл байдалтай танилцаж, холбогдох баримт (баримт бичиг, зураг, дүрс бичлэг) бүрдүүлэн хуралд мэдээлэх бөгөөд хүүхдийг биечлэн ирүүлэхгүйгээр оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнгийн талаар баримт бичиг, холбогдох материалд үндэслэн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах асуудлыг хэлэлцэнэ.

5.9.Салбар комисс энэ дүрмийн 5.6.3-т заасан хэлбэрээр хуралдах тохиолдолд хүүхдийг биечлэн ирүүлэхгүйгээр мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулж, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үр дүн, холбогдох материалд үндэслэн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах асуудлыг хэлэлцэнэ.

5.10.Салбар комиссын үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх зорилгоор алслагдсан сум, тосгон, багт Салбар комиссын хуралдааныг энэ дүрмийн 5.6.4-т заасан хэлбэрээр зохион байгуулж, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үр дүн, холбогдох материалд үндэслэн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах асуудлыг хэлэлцэнэ. Нүүдлийн хурлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн орон нутаг хариуцна.

5.11.Салбар комиссын хурлаас гарах шийдвэр нь эрх бүхий байгууллагаас баталсан өвчин, гэмтлийн жагсаалтыг үндэслэсэн байна.

5.12.Салбар комиссын хурлыг хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүндрэл бэрхшээл учруулахгүй, урьдчилан цаг товлож, дараалал үүсгэхгүйгээр шуурхай зохион байгуулна.

5.13.Салбар комиссын хурлыг зохион байгуулах байр нь хүртээмжтэй байна.



## Зургаа.Салбар комиссын гишүүдийн урамшуулал

6.1.Салбар комиссын дарга нь аймаг, дүүргийн Засаг дарга болон Төв комиссын даргатай гурвалсан гэрээ, Салбар комиссын гишүүдтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллана.

6.2.Салбар комиссын дарга, гишүүдэд хуралд оролцсон цаг, оролцоо, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид өгсөн зөвлөгөө, идэвхийг нь харгалзаж урамшуулал олгоно. Урамшууллыг Засгийн газраас баталсан “Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”-д заасан хэмжээгээр олгоно.

6.3.Салбар комиссын нарийн бичгийн дарга нь гишүүдийн хуралд оролцсон цагийн тооцоо, хурлын идэвх, оролцоог нэгтгэн хурлын тэмдэглэл хөтөлж, Салбар комиссын даргаар баталгаажуулан улирал бүрийн эхний сарын 1-ний дотор Төв комисст хүргүүлнэ.

6.4.Төв комисс нь Салбар комиссын хурлын тэмдэглэл, гишүүдийн хуралд оролцсон цагийн тооцоо, идэвх, оролцоог хянан үзсэний үндсэн дээр Төрийн сангаар дамжуулан урамшууллыг улирал бүрээр тооцож олгоно.

Долоо.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд,  
боловсрол, нийгмийн хамгааллын мэдээллийн сан

7.1.Төв болон Салбар комисс нь үйл ажиллагаандаа ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх)-тай байна.

7.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Төв болон Салбар комиссын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, ил тод болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, хяналт шалгалт хийх, төрийн байгууллага хооронд мэдээлэл харилцан солилцох, бусад цахим үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.3.Мэдээллийн нэгдсэн санд Төв болон Салбар комиссоос гаргасан бүх шийдвэрийг бүртгэж, хөтлөхөөс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой дараах мэдээллийг нэгтгэнэ:



7.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн овог нэр, регистрийн дугаар, нас, хүйс, хаяг, харьяалал (аймаг, дүүрэг, сум, баг, хороо, тосгон), холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, шаардлагатай үед холбоо барих хүний мэдээлэл;

7.3.2.хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, байнгын асаргаанд хамруулах, сунгах, цуцлах хугацаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах шийдвэрийн тухай мэдээлэл;

7.3.3.энэ дүрмийн 7.3.2-т заасан шийдвэрийг гаргасан Салбар комиссын гишүүдийн овог нэр, холбоо барих утасны дугаар;

7.3.4.хүүхдийн хувийн хэрэг, өвчний түүх, амбулаторийн карт, оношилгоо, багажийн болон лабораторийн шинжилгээний дүгнэлт;

7.3.5.эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан тухай мэдээлэл;

7.3.6.боловсролын үйлчилгээнд хамрагдсан тухай мэдээлэл;

7.3.7.нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан тухай мэдээлэл;

7.3.8.Төв болон Салбар комиссын цахимаар ирүүлсэн шийдвэрийн мэдээлэл;

7.3.9.асуудал шийдвэрлэсэн бодит жишээ (кэйс), баримт;

7.3.10.шаардлагатай бусад мэдээлэл.

7.4.Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь зөвхөн тухайн хүүхдийн хамаарал бүхий мэдээллийг мэдээллийн нэгдсэн сангаас гаргуулан авч болно.

7.5.Төв болон Салбар комиссын нарийн бичиг дарга нь тухайн комиссын шийдвэр болон бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас авч тухай бүр мэдээллийн нэгдсэн санд оруулна. Мэдээллийн нэгдсэн санд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн комиссын дарга баталгаажуулна.





7.6.Мэдээллийн нэгдсэн сан дахь 16 нас хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн холбогдох мэдээллийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст шууд шилжүүлнэ.

7.7.Төв болон Салбар комисс энэ дүрмийн 7.3-т заасан мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

#### Найм.Салбар комиссын үйл ажиллагаанд тавих хяналт

8.1.Төв комисс нь Салбар комиссын үйл ажиллагаа, цахим болон цаасан бичиг баримт, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

8.2.Төв комисс мэдээллийн нэгдсэн санг ашиглан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр улсын дунджаас дээш эрсдэлтэй нөхцөл бүхий Салбар комиссын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтыг шаардлагатай тохиолдолд Төв комиссын дэргэдэх орон тооны бус зөвлөлтэй хамтран хийж болно.

8.3.Хяналт, шалгалт хийхэд хараат бус хөндлөнгийн шинжээч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, эцэг, эхчүүдийн төлөөллийг оролцуулж болно.

8.4.Салбар комисс нь нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын болон боловсролын салбарын холбогдох цахим мэдээллийн санг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдсан байдалд хяналт тавина.

#### Ес.Бусад

9.1.Төв болон Салбар комисс нь хууль, энэ дүрэмд заасныг зөрчсөн дараах албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ:

9.1.1.үндэслэлгүй шийдвэр гаргасан, үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй Салбар комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн даргад;



9.1.2.хуурамч баримт бичиг үйлдэж хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоолгох болон байнгын асаргаанд хамруулахыг завдсан, тогтоолгосон, асаргаанд байх хугацааг сунгуулсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид;

9.1.3.худал онош тавьсан хяналтын болон эмчлэгч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, багажийн болон лабораторийн шинжилгээг хуурамчаар үйлдсэн ажилтанд;

9.1.4.хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоолгох, байнгын асаргаанд хамруулах, асаргаанд байх хугацааг сунгуулах зорилгоор комиссын гишүүдэд хууль бусаар нөлөөлсөн албан тушаалтан, бусад этгээдэд;

9.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулаагүй, эрхийг нь зөрчиж байгаа байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид.

9.2.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоосон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (Эрүүл мэндийн төв)-ийн нарийн мэргэжлийн эмч нарын тодорхойлолт нь тухайн хүүхдийг Салбар комиссын хурлаар орох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2022 оны 03 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр  
зүйлийн 51.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн  
холбогдох заалтад нийцсэн эсэх маргааныг  
хянан хэлэлцсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг  
Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн  
цэцийн гишүүн Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Ж.Эрдэнэбулган,



Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Т.Ариунболд болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй. ...” гэж заасанд тус тус нийцсэн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Т.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж:***

“Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй.” гэж заасантай тус тус нийцээгүй тул уг заалтыг хүчингүй болгуулахаар мэдээлэл гаргаж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад ““Хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг;”, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт зааснаар шүүгчийн үйл ажиллагаа нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөлд хамаардаг. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалтад зааснаар шүүгчид тавих болзол шаардлагад “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй

байх;” гэж зааснаас үзэхэд шүүгч нь бусад хуульчийн адил Хуульчдын холбооны гишүүн бөгөөд шүүгчээр томилогдохдоо хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байхаар органик хуульд зохицуулсан байна. Тэгвэл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Прокурорын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд нь прокуророор томилогдож, өмгөөлөгчийн шалгалт өгч өмгөөлөгчөөр ажиллахаар зохицуулсан хуулиуд одоо хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Өөрийн хүсэлтээр шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.” гэж заасан бөгөөд энэ нь тухайн шүүгчийг 2 жилийн хугацаанд өмгөөлөгч хийхгүй, хуульчаар ажиллахдаа урьд шүүгчээр ажиллаж байсан нөлөөллийг сарниулах, мөн өмгөөлөгчийн шалгалтад орж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг авах хууль зүйн зохицуулалтыг оруулан хязгаарласан гэж үзэж байна. Харин шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно гэж заасан нь хуульчийн үндсэн эрхийг зөрчиж байна. Шүүгчийн албан тушаалаас огцорсон, өндөр насны тэтгэвэрт гарснаар тухайн хуульчийн Хуульчдын холбооны гишүүний эрх нь хүчингүй болох зохицуулалт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдаагүй, мөн хуульч хүн Өмгөөллийн тухай хуульд зааснаар өмгөөлөгчийн шалгалтад орох зохицуулалт нь хязгаарлагдаагүй байна.

Тэгвэл 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Прокурорын тухай хуулийн иргэний эрхэд тавих хяналт болон ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтад прокурор нь өндөр насны тэтгэвэрт гарсны дараа өмгөөлөгч хийж болохгүй гэсэн зохицуулалт байхгүй. 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Өмгөөллийн тухай хуульд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгосон тохиолдолд тухайн хуульчийг бусад өөр ажил, албан тушаал эрхлэхийг хориглосон, хязгаарласан зохицуулалт байхгүй. Мөн бусад хуульч нарын хувьд ч тухайн ажил албан тушаалаа эрхлэхээ больсны дараа өөр ажил, албан тушаал эрхлэхийг нь хориглосон, хязгаарласан хуулийн зохицуулалт байхгүй байхад шүүгчийг онцгойлон өндөр насны тэтгэвэрт гарснаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоод байгаа нь хууль зүйн үндэслэлгүй юм. Прокурор өндөр насны тэтгэвэрт гарсны дараа өмгөөлөгчөөр ажиллах боломж хуульд байгаа, мөн өмгөөлөгч сайн дурын даатгалд хамрагдаж өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ч өмгөөллийн үйл



ажиллагаа эрхлэхийг нь хуулиар хориглоогүй, нарийвчлан зохицуулагдсан Өмгөөллийн тухай хуулиар нээлттэй байхад шүүгчийг онцгойлон өндөр насны тэтгэвэрт гарсан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон нь Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтуудтай нийцээгүй байна. Шүүгчээр ажилласан хуульчийг илтэд ялгаварлан гадуурхаж, хууль зүйн үндэслэлгүй. Шүүгчийн албан тушаал эрхлэхээ болсны дараа өмгөөлөгчөөр ажиллахад шүүхэд нөлөөлнө гэх мэт тодорхой асуудлаар таамаглал төдий зүйл дэвшүүлэн эрхийг нь зөрчсөн хуулийн заалтыг Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа нь өөрөө Үндсэн хуульд нийцэхгүй, Үндсэн хуулийн зарчимд харшилсан байна.

Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалт /цаашид “өмгөөлөгчийн шалгалт” гэх/-д тэнцэж, өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, эрх авсан хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ.”, 7.2 дахь хэсэгт “Өмгөөлөгчийн шалгалтад тэнцсэн хуульч шалгалтын нэгдсэн дүнг мэдээлсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авах тухай хүсэлтийг Монголын Өмгөөлөгчдийн Холбоо /цаашид “Өмгөөлөгчдийн Холбоо” гэх/-нд гаргана. ...” гэж хуульчилсан бөгөөд өмгөөлөгчийн шалгалтад шүүгчээр ажиллаж өндөр насны тэтгэвэрт гарсан хуульчийг оруулахгүй байх, түүнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх өгөхгүй байхаар зохицуулаагүй, хуульчлаагүй. Өөрөөр хэлбэл, өмгөөллийн үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль болох Өмгөөллийн тухай хуульд бүх хуульч нарт өмгөөлөгчийн шалгалтад тэнцсэн тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохоор хуульчилсан байхад Монгол Улсын шүүхийн тухай хуульд Өмгөөллийн тухай хуультай илт харшилсан, Үндсэн хуультай нийцээгүй хуулийн зүйл, заалтыг баталсан нь хууль бус юм. Мөн салбар хуулийн үзэл санаанаас гажсан, ойлгомжгүй байгааг дурдъя.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг хүчингүй болгуулж өгнө үү.” гэжээ.

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дечин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Энэхүү шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүхийн нэр хүнд

“шүүгч”-тэй холбоотой билээ. Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 1.6-д “Шүүгч шүүхийн стандартыг хэрэгжүүлэхдээ бусдад үлгэр дууриал болохуйц байж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ.” гэж, 3.2-т “Шүүгч өөрийн үйл ажиллагаа, зан байдлаар бусдын шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллана.” гэж шүүгч өөрийн үйл ажиллагаагаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хангахад чухал үүрэг, оролцоотой байх талаар зохицуулжээ.

Шүүгчийн мэргэжлийн үүрэг буюу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч, хүний амьдралын, бизнесийн, улс орны хамгийн чухал маргаантай асуудлыг төрийн нэрийн өмнөөс шийдвэрлэдгийн хувьд түүнд төрийн бусад албан хаагчдад тавигддаг мэргэжлийн, сахилгын болон ёс зүйн шаардлагаас илүү өндөр шалгуур, шаардлага, хязгаарлалтыг тавьдаг. Шударга ёсны баталгаа болдог шүүгч нар олон нийтийн итгэлийг хүлээхүйц өндөр ёс зүйтэй байж, хараат бусаар ажиллах шаардлагатай байдаг.

Дэлхийн өрсөлдөх чадварын үнэлгээгээр шүүхийн хараат бус байдлын хүрээнд манай улс дэлхийн 140 гаруй улсаас 2011 онд 122-т, 2016 онд 100-д жагсаж байсан бол 2018 онд 113-т, 2019 онд 120-д жагсаж буурч эрэмбэлэгдсэн байна. Түүнчлэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд шүүгчийн хараат бус байдал, шүүх дэх нөлөөллийг судлах зорилгоор 2019-2020 онд Монгол Улсын нийт 501 шүүгчээс авсан анкет судалгаагаар “танил тал, найз нөхдийн харилцааны журмаар гуйх” нөлөөлөл хамгийн өндөр буюу 40 орчим хувийг эзэлсэн байдаг. Мөн сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн хараат бус байдлыг үл хүндэтгэсэн зохисгүй үйлдлийг хамгийн олон удаа гаргасан субъектүүдээс өмгөөлөгч хоёрдугаарт буюу хэргийн оролцогчийн дараа эрэмбэлэгдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэж, Шүүхийн хараат бус байдлын талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь зарчмын 2-т “шүүх аливаа хэргийг тал харалгүй, хэний ч нөлөөнд авталгүйгээр нотлох баримтад үндэслэн хуульд нийцүүлэн ... шийдвэрлэнэ.” гэж тус тус заасан. Эдгээр нь хэргийг шийдвэрлэх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч хэргийн оролцогчидтой харилцах харилцаанаас



хамаарч шүүгчийг сэжиглэх, хардах, хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд эргэлзээ төрөх үндэслэл бий болж болохыг илэрхийлж байна.

Бусдын нөлөөнд автаагүй, хараат бус, шударга ёсыг эрхэмлэдэг шүүгчээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж байгаа иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... шударга шүүхээр шүүлгэх ..." гэсэн үндсэн эрхээ баталгаатай эдлэх бөгөөд хуулийг дээдэлсэн, гагцхүү хуульд захирагддаг шударга шүүхэд хандаж зөрчигдсэн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулж байгаадаа итгэл дүүрэн байх болно.

Ийнхүү хууль тогтоогчийн хувьд Үндсэн хууль болон олон улсын баримт бичигт заасан дээрх суурь зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс цөөн хүн амтай, ажил хэрэгт танил талын нөлөөлөл их байдаг өөрийн орны онцлогийг харгалзан шүүгчийн хараат бус байдлыг хангах нэг нөхцөл болсон түүний үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах механизмыг бүрдүүлэх зорилгоор уг зохицуулалтыг хийсэн бөгөөд энэ нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл байсан билээ.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгч хараат бусаар ажиллаж, зөвхөн хуульд захирагдаж, хууль хэрэглэдэг субъект мөртлөө хуульд тусгайлан зааж хориглосон мэргэжлийн, ёс зүйн, сахилгын зөрчил гаргаж огцорсон нь тухайн шүүгчийн мэргэжлийн болон хувь хүний ёс зүй, хандлага, хариуцлагынх нь илэрхийлэл болох юм. Шүүгч албан ажил төдийгүй хувийн амьдралдаа ёс зүйтэй байж, нийгмийн хүндэтгэл, итгэлийг авч, шүүгчийн хариуцлагыг ухамсарлан хэрэгжүүлж чадаагүй нь түүнийг цаашид мэргэжлийн хувьд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй, ёс зүйн шаардлага хангахгүй гэж үзэх үндэслэлтэй. ...

Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэж байгаа өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрхийг хангахуйц мэргэжлийн өндөр мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүйн хувьд шударга байх шаардлагыг хангаж чадахгүй бол шударга ёс, тэгш байдлыг хангасан байх Үндсэн хуулийн суурь зарчим алдагдахад хүрэх болно.

3. Шүүгч Үндсэн хуулиар хамгаалагдсан тусгай эрхтэй, түүнийг Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглосон. Өөрөөр хэлбэл, шүүгчийн өөрийн үйл ажиллагаанаас хамааралтай,

Үндсэн хууль, бусад хуульд заасан эдгээр нөхцөл үүсээгүй тохиолдолд түүний шүүгчээрээ ажиллах баталгаа нь хангагдсан байдаг. Энэ нь тэтгэвэрт гартлаа буюу 20-40 жил шүүгчээр ажиллаж салбартаа танигдаж, нэр хүнд, танил тал, найз нөхдийн өргөн хүрээлэлтэй болох нөхцөлийг тухайн шүүгчээс үл хамааралтайгаар бүрдүүлэх учраас нөгөө талдаа ийм хүрээлэл бүхий этгээд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх нь шүүгчид нөлөөлөх боломжийг нээж байгаа хэрэг юм.

4.Огцорсон, тэтгэвэрт гарсан шүүгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хуулиар хязгаарласан нь тухайн этгээдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан бусад эрхийг хөндөхгүй, өмгөөллөөс бусад ажил, үйлчилгээ эрхлэх эрх нь нээлттэй байна. ... Өөрөөр хэлбэл, албан тушаалтан нь иргэнийхээ хувьд Үндсэн хуульд заасан эрхээ тэгш, ялгаварлан гадуурхагдалгүйгээр эдлэх боловч “шүүгч” гэдэг албан тушаалтны хувьд эдэлж байсан бүрэн эрх, ёс зүй, хариуцлагатай холбоотойгоор албан тушаалынх нь онцлогоос шалтгаалан зөвхөн өмгөөлөгчөөр ажиллахыг хориглосон хязгаарлалтыг хуулиар тавьж болно гэж үзэж байна. Хууль тогтоогч эрх зүйн байдлын хувьд илт давуу нөхцөл бүхий буюу эрх нөлөө, давуу байдлаа ашиглах боломжтой субъектэд ийнхүү ялгаатай хуулийн зохицуулалт хэрэглэж, холбогдох шаардлагыг хуулиар тавих нь эрх зүйт төрийн суурь зарчмуудын нэг бөгөөд энэ нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн нэр хүнд, шүүгчийн хараат бус байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр гэж үзэж байна.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, ... -ыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.” гэсэн байна. Эндээс үзэхэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд ч иргэдийн эрх, ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх этгээдэд хуулиар хязгаарлалт, шаардлага тавих нь зүй ёсны хэрэг бөгөөд үүнийг ялгаварлал гэж үзэхгүй болохыг баталгаажуулж байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим нь аливаа этгээдэд адил шударга, хүндэтгэлтэй хандаж, хуулийг чанд, нэг мөр хэрэглэх агуулгыг илэрхийлдэг. Тодорхой тохиолдолд буюу субъектийн эрх зүйн байдал, нийгэмд үзүүлэх нөлөөг харгалзан ялгаатай зохицуулалтыг





хийх нь “хуулийн өмнө эрх тэгш байх” зарчмыг хөндөхгүй бөгөөд харин ч шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчдийг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгаараа нийгэмд илүү эерэг үр нөлөө үзүүлэх зохицуулалт болж, шударга ёсны зарчимд нийцнэ гэж үзэж байна.

6.Мэдээлэл гаргагч Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Өмгөөллийн тухай хуулиудыг шинэчлэн найруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нийцүүлээгүй тухай мэдээлэлдээ дурдсан байсан. Гэтэл Улсын Их Хурлаас хууль хоорондын уялдааг хангах зорилгоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.5 дахь заалтад шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон бол түүнийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байх нэмэлтийг хийсэн байгаа.

Харин Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухайд уг хууль нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой суурь харилцааг зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, огцорсон, тэтгэвэртээ гарсан шүүгч зөвхөн шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ. Харин хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх, зөвлөмж, дүгнэлт гаргах, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиох, төрийн болон бусад байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх зэрэг хууль зүйн мэргэжлийн бусад үйл ажиллагааг эрхлэх боломжтой гэж үзсэн учраас уг хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн болно.

Иргэд олон нийтийн дунд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах салбарын нэр хүнд унасан өнөө үед Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүхэд итгэх итгэлийг сэргээх, шударга бус үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүмүүсийн албан тушаалын болон ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлагыг хангахад чиглэгдсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиудад бэхжүүлсэн нь Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасан өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд бодлогын чанартай шийдсэн асуудал юм.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг зөрчөөгүй.” гэсэн байна.

***Гурав.Монголын Хуульчдын Холбооноос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан зохицуулалт нь шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалттай холбоотой байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалтыг тусгасан бөгөөд тус зүйлийн 21.1 дэх хэсэгт “Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:” гээд 21.1.1 дэх заалтад “урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;”, 21.1.2 дахь заалтад “урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;”, 21.1.3 дахь заалтад “урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.” гэж заасан.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт “Хуульчийн мэргэжлийн дүрмээр хуульч, үйлчлүүлэгч, хуульчид хоорондын харилцаа, хуульчдын нийтийн өмнө хүлээх үүрэг, ашиг сонирхлын зөрчил, нууцлал, эрх хэмжээ, хараат бус байдал болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулна.” гэж заасан бөгөөд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хуульч үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчид ашиг сонирхлын зөрчил бий болгохоор байвал үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.” гэж заасан.

Дээрх хууль, дүрмийн зохицуулалтын дагуу ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг зохицуулах боломжтой байх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэх шалтгаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин

суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй. ...” гэснийг зөрчиж болохгүй гэж үзэж байна.” гэжээ.

***Дөрөв. Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.5 дахь заалтад “шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон, ...” бол өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзахаар тодорхой хуульчилсан бөгөөд энэхүү хориглосон заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох” эрхийг зөрчөөгүй гэж үзэхээр байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах, хөдөлмөрийн насны иргэнд хамаарах заалт бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд орсон энэхүү хориглосон заалт нь шүүн таслах ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, шүүхийн хараат бус байдлыг хамгаалах хуулийн зохицуулалт гэж үзэж байна.” гэсэн байна.

**ҮНДЭСЛЭЛ:**

1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.” гэж заасан нь шүүгчийн бүрэн эрх, онцгой чиг үүрэг, ёс зүй, хариуцлагатай холбогдуулан эрхэлж байсан албан тушаалын онцлогоос нь шалтгаалан өмгөөлөгчөөр ажиллахыг хориглосон зохицуулалт байна.

2.Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон /Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр соёрхон баталсан/ Алагчилахгүй байх (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Тодорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг “алагчилах” хэмээх ойлголтод хамааруулахгүй.”

гэж заасан. Шүүгчийн гүйцэтгэж байгаа мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдуулан, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг баталгаажуулах хүрээнд хийсэн дээрх хязгаарлалт нь алагчилах хэмээх ойлголтод хамаарахгүй байна.

3.Шүүгчийн бүрэн эрх, чиг үүргийн онцлог, ёс зүй, хариуцлага, мөн гүйцэтгэж байгаа мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан тухайн албан тушаалаас огцорсон бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор заасан нь тэгш эрхийн зарчмыг хөндөөгүй байх бөгөөд ийм хязгаарлалтыг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог бусад этгээдэд нийтлэг байдлаар тогтоосон байна. Тодруулбал, Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт энэ талаар тодорхой зохицуулалтыг тусгажээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг нь шүүгчээр ажиллаж байсан иргэний өмгөөллөөс бусад ажил, үйлчилгээ эрхлэх эрхийг хязгаарлаагүй бөгөөд шүүгч болон өмгөөлөгчийн үйл ажиллагааны мөн чанар, чиг үүрэг, хамрах хүрээтэй нь уялдуулж тогтоосон зохицуулалт байх тул Үндсэн хуулиар хамгаалагдсан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хөндөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “Шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй. ...” гэж заасанд тус тус нийцсэн байна.



2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Г.БАЯСГАЛАН**

**ГИШҮҮД**

**Б.БУЯНДЭЛГЭР**

**Ц.НАНЗАДДОРЖ**

**Ж.ЭРДЭНЭБУЛГАН**

**Д.ГАНГАБААТАР**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

**Индекс: 200003**